

Монгол Улсын Статистикийн салбарын бүх шатны ажилтнууд танай өрх болон хувь хүний нууцыг "Хувь хүний нууцын тухай", "Статистикийн тухай" 22 дугаар зүйлийн 3 дугаар заалтын дагуу мэдээллийн нууцыг хадгална.

Үндэсний статистикийн хорооны даргын
2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн
А/163 дугаар тушаалын 4 дүгээр хавсралт

ӨРХИЙН ӨДРИЙН ТЭМДЭГЛЭЛ

/7 хоногийн хэрэглээг тэмдэглэнэ/

Улирал	Түүврийн нэгжийн дугаар	Өрхийн дугаар

1. ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ОВОГ, НЭР _____

2. ӨРХИЙН ХАЯГ _____

3. МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАГЧИЙН НЭР, КОД _____

Код

--	--

4. ӨДРИЙН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН ОГНОО:

	Он	Сар	Өдөр
1 дэх хоног			
2 дахь хоног			
3 дахь хоног			
4 дэх хоног			
5 дахь хоног			
6 дахь хоног			
7 дахь хоног			

5. ТАНАЙД ӨДРИЙН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН 7 ХОНОГТ 1 БА ТҮҮНЭЭС ОЛОН ХОНОГООР ХҮН ЗОЧИЛСОН УУ, ХЭДЭН ХҮН БАЙСАН БЭ? (ЗОЧНЫ ТООГ БИЧНЭ)

Тоо

--	--

6. НИЙТ ХЭД ХОНОСОН БЭ? (ЗОЧНЫ ТООГ ХОНОСОН ӨДРӨӨР НЬ ҮРЖҮҮЛЖ БИЧНЭ)

Хүн/өдөр

--	--

7. ТУХАЙН ХУГАЦААНД ӨРХӨД ОЧСОН ҮР ДҮН

	Он	Сар	Өдөр	Үр дүн*
Очилт 1:				
Очилт 2:				
Очилт 3:				

Үр дүнгийн код*

Нөхөлт хангалттай - 1

Нөхөлт хангалтгүй - 2

ТЭМДЭГЛЭЛ:

Өрхөд үлдэх өдрийн тэмдэглэлийг нөхөх заавар

Энэ өдрийн тэмдэглэл нь танай өрхийн долоо хоногт хэрэглэсэн хүнсний зүйлийг бүх нэр төрлөөр тэмдэглүүлж авах зорилготой юм. Өдрийн тэмдэглэл нь нүүр хэсэг, заавар, өрхийн хүнсний зүйлийн хэрэглээ, гэрээсээ гадуур хэрэглэсэн өрхийн хүнсний зүйлийн гэсэн хэсгүүдээс бүрдэнэ.

I. НҮҮР ХЭСЭГ: Энэхүү хэсэг нь

- Судалгаа явагдаж байгаа улирал
- Түүврийн нэгжийн дугаар
- Өрхийн дугаар
- Өрхийн тэргүүлэгчийн овог, нэр
- Өрхийн хаяг
- Мэдээлэл цуглуулагчийн нэр, код
- Өдрийн тэмдэглэл хөтөлсөн он, сар, өдрүүд
- 1, түүнээс олон хоногоор хоносон зочны тоо, хоносон хүн, өдөр
- Судалгааны хугацаанд өрхөд очсон тоо зэргээс бүрдэх ба мэдээлэл цуглуулагч нөхнө.

II. ЗААВАР: Өрхөд үлдээх өдрийн тэмдэглэлийн тухай болон өрхийн гишүүд хүнсний зүйлийн хэрэглээгээ хэрхэн нөхөх талаар зааварчилсан байна.

III. ХЭСЭГ А. ӨРХИЙН ХҮНСНИЙ ХЭРЭГЛЭЭ

Энэ хэсэгт танай өрхийн гишүүд өдөр бүрийн хүнсний бүтээгдэхүүнийхээ хэрэглээг нэр төрөл бүрээр зааврын дагуу тоочин тэмдэглэх ёстой ба танай өрхийн долоо хоногийн хүнсний хэрэглээний хэмжээ бүртгэгдэх юм. Нэг өдрийн хүнсний хэрэглээг нэг хуудсан дээр бүртгэнэ. Хуудас бүрт тухайн нэг өдрийн туршид хэрэглэсэн хүнсний зүйл бичих 15 мөр байгаа. Мөр бүр 4 оронтой тоогоор дугаарлагдсан. Үүнд: Эхний 2 орон: өдрийн дугаар, 3-4 дэх орон: тухайн өдөр хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийн дугаарыг илэрхийлнэ.

1. Өрхийн гишүүдийн тэмдэглэл хөтлөх хэсэг (Багана 1, 2, 3, 4, 5, 6)

Танай өрхийн гишүүд хүнсний зүйл хэрэглэх бүртээ түүнийгээ өдрийн тэмдэглэлд дараах байдлаар бичнэ үү.

Багана 1-д хэрэглэсэн хүнсний зүйлийн **нэрийг** маш тодорхой бичнэ. Бичигдсэн нэр төрлөөр мэдээлэл цуглуулагч дараа нь нэгтгэх учраас нэрийг тодорхой бичих шаардлагатай юм. Жишээ нь, махыг бичихээр бол хонины мах, адууны мах, будааг бичих бол шар будаа, цагаан будаа, гурилыг бичих бол 1-р гурил, 2-р гурил гэх мэтчилэн нэр төрлийг тодорхой бичихээс гадна мөр тус бүрт салгаж бичнэ. Мөн ургамлын тос, шар тос, монгол тамхи, зөөлөн чихэр, хатуу чихэр, хэрчсэн гурил гэх мэтээр тодотгож бичээрэй.

Багана 2-т Багана 1-д тодорхойлж бичсэн хүнсний зүйлийн хэрэглэсэн тоо хэмжээг бичнэ. Жишээ нь, 1 килограмм, 350 грамм, 0.5 литр, 3 литр, 1 хайрцаг гэх зэргээр хэмжих нэгжээ давхар бодож тоо хэмжээгээ бичих хэрэгтэй. Килограмм, литр, ширхэг гэх мэтээр стандарт хэмжих нэгжээр (Жишээлбэл: 1 килограмм, 350 грамм, 4 алим, хагас шил, нэг боодол гэх зэргээр) бичих боловч танай өрхийн гишүүд өөрсдийн боломжоороо хэмжин тодорхой бичиж болно. Харин мэдээлэл цуглуулагчийг эргэн тодруулах үед хэмжээг нарийвчлан гаргахад туслаарай.

Багана 3-т хэрэглэсэн хүнсний зүйлийнхээ эх үүсвэрийг тодорхойлно. Худалдан авсан, бусдаас үнэгүй авсан, өөрийн аж ахуйгаас хэрэглэсэн гэсэн гурван эх үүсвэрийн кодоос тохирох кодыг сонгоно. Хэрэв худалдан авсан болон бусдаас үнэгүй авсан, өөрийн аж ахуйгаас хэрэглэсэн аль аль нь байгаа тохиолдолд тухайн нэр төрлийн хүнсний зүйлийг салгаж дараагийн мөрөнд дахин бичнэ. Жишээ нь, үхрийн махыг худалдан авсан, айлаас өгсөн, эсвэл өөрсдийн малаас гаргасан байж болох учир үхрийн махаа 3 мөрөнд дарааллууж (Багана 1-д үхрийн мах, Багана 2-т "500 грамм", Багана 3-т **худалдан авсан** буюу "1", мөн Багана 1-д үхрийн мах, Багана 2-т "1 кг", Багана 3-т **бусдаас үнэгүй авсан** буюу "2", мөн Багана 1-д үхрийн мах, Багана 2-т "500 грамм", Багана 3-т **өөрийн аж ахуйгаас** буюу "3" гэх зэргээр салгаж бичнэ).

Багана 4-т тухайн хэрэглэсэн нэр төрлийн хүнсний зүйлийг **сүүлийн 30 хоногт** худалдан авсан эсэхийг асууж байгаа учир хэрэв Тийм бол "1" кодыг, Үгүй буюу сүүлийн 30 хоногоос өмнө худалдан авсан бол "2" кодыг бичнэ.

Багана 5-д тухайн хэрэглэсэн хүнсний зүйлийг Багана 4-т сүүлийн 30 хоногт худалдан авсан "1" гэж кодлосон тохиолдолд тухайн нэр төрлийн хүнсний зүйлийг хамгийн сүүлд хэдий хэмжээгээр худалдан авсан эсэхийг асууж байна. Иймд худалдан авсан тоо хэмжээг хэмжих нэгжийн хамт Багана 5-д бичнэ.

Багана 6-д тухайн хэрэглэсэн хүнсний зүйлийг худалдан авахад хэдэн төгрөг зарцуулсан талаар асууж байна. Өөрөөр хэлбэл, Багана 5-д бичсэн худалдан авсан тоо хэмжээг хэдэн төгрөгөөр худалдан авсныг бичнэ.

2. Мэдээлэл цуглуулагч нөхөх хэсэг (Багана 7, 8)

Багана 7-д стандарт хэмжээ: Мэдээлэл цуглуулагч **Багана 5-д** бичсэн нэгжийг стандарт хэмжих нэгжид шилжүүлж бичнэ. "ӨНЭЗС-2а" маягтад бүх нэр төрөл стандарт хэмжих нэгжээр бичигдэх ёстой. Жишээлбэл: хагас уут будаа гэж бичсэн байвал мэдээлэл цуглуулагч өрхөөс тодруулан тэр хэмжээг килограммд шилжүүлж бичнэ. Хэрэв тухайн өрх стандарт хэмжих нэгжээр бичсэн байвал заавал хуулж бичих шаардлагагүй.

Багана 8-д худалдан авсан нэгжийн стандарт үнэ: Мэдээлэл цуглуулагч **Багана 6-д** бичигдсэн худалдан авсан зардлаас нэгжийн үнийг тооцож стандарт нэгжийн үнэд шилжүүлж бичнэ. Жишээ нь 700 граммын хэмжээтэй жимсний чанамал, нухашыг 9500 төгрөгөөр худалдан аваад нэгжийн үнийг 9500 төгрөг гээд бичсэн байвал мэдээлэл цуглуулагч жимсний чанамал, нухашны стандарт хэмжих нэгж нь грамм учраас 1 граммын үнийг олж 14 төгрөг гэж бичнэ. Хэрэв тухайн өрх стандарт нэгжийн үнээр бичсэн бол заавал хуулж бичих шаардлагагүй.

Хүснэгт 1-д гарын доорх эд материалыг ашиглан хүнсний зүйлийг граммаар хэмжих товч зөвлөмжийг харуулав.

Хүснэгт 1. Бүтээгдэхүүний жин, граммаар

№	Бүтээгдэхүүн	СТАКАН 250 МЛ	ХООЛНЫ ХАЛБАГА	ЦАЙНЫ ХАЛБАГА
1	Кофе	-	20	7
2	Гурвалжин будаа	300	35	10
3	Хөц будаа	90	12	6
4	Хүүхдийн будаа	160	15	4
5	Шар будаа	220	25	8
6	Цагаан будаа	240	30	1
7	Ургамлын тос	200	10	3
8	Зегийн бал	370	35	10
9	Сүү	250	20	5
10	Цөцгийн тос	250	14	5
11	Цөцгий	300	20	7
12	Гурил	160	30	10
13	Сахар	200	17	4
14	Цай	-	15	-
15	Давс	290	30	10

IV. ХЭСЭГ Б. ГЭРЭЭСЭЭ ГАДУУР ХЭРЭГЛЭСЭН ӨРХИЙН ХҮНСНИЙ ХЭРЭГЛЭЭ

Энэ хэсэгт Хэсэг А-д задалж бичих боломжгүй танай өрхийн гишүүд гэрээсээ гадуур албан газар, сургууль, ресторан, кафе, зоогийн газар, цайны газар болон дэлгүүрээс худалдаж авсан эсвэл бусдаар худалдан авахуулсан өрхийн хүнсний хэрэглээнүүд болох өглөөний цай, өдөр, оройн хоол, зууш, ус, ундаа, кофе, цай, архи согтууруулах ундаа, гэрээсээ өөр газар бэлтгэсэн бэлэн хоол, хүнсийг гэртээ авчирч идсэн зэрэг хэрэглээг өдрийн тэмдэглэлд бүртгэнэ.

Багана 9. Гэрээсээ гадуур хооллосон хүнсний хэрэглээг өглөөний цай, өдрийн хоол, оройн хоол, зууш, ус, ундаа, кофе, цай, архи согтууруулах ундаа, гэртээ авчирч хооллосон бэлэн хоол, хүнс гэсэн долоон нэр төрлийн хувьд өдрийн тэмдэглэлд салгаж бүртгэсэн.

Багана 10. Өдрийн тэмдэглэл хөтөлж буй өдөр өглөөний цай, өдрийн хоол, оройн хоол, зууш, ус, ундаа, кофе, цай, архи согтууруулах ундаа, гэртээ авчирч хооллосон бэлэн хоол, хүнс тус бүрээр гэрээсээ гадуур хооллосон эсэхийг бүртгэнэ. Хэрэв танай өрхийн аль нэг гишүүний хувьд Тийм бол "1"-ийг дугуйлна, Үгүй бол "2"-ыг дугуйлна.

Багана 11. Өдрийн тэмдэглэл хөтөлж буй өдөр өглөөний цай, өдрийн хоол, оройн хоол, зууш, ус, ундаа, кофе, цай, архи согтууруулах ундаа, гэртээ авчирч хооллосон бэлэн хоол, хүнс тус бүрийн хувьд хэдэн удаа хооллосон тоог нөхнө. Өрхийн гишүүн тус бүрээр 1 гэж тоологдоно. Жишээ нь, өрхийн 2 гишүүн өдрийн хоолоо албан газрынхаа цайны газарт хооллосон бол энд 2 гэж нөхөгдөнө.

Багана 12. Өдрийн тэмдэглэл хөтөлж буй өдөр өглөөний цай, өдрийн хоол, оройн хоол, зууш, ус, ундаа, кофе, цай, архи согтууруулах ундаа, гэртээ авчирч хооллосон бэлэн хоол, хүнс тус бүрийн хувьд худалдан авахад нийт хэчнээн төгрөг зарцуулсныг бичнэ. Жишээ нь, Өрхийн 2 гишүүн 10000, 7000 төгрөгийн үнэтэй өдрийн хоол албан газрынхаа цайны газраасаа худалдан авч идсэн бол энд 17000 төгрөг гэж нөхөгдөнө. Хоол нь олон төрлийн хүнсний зүйлээс бүрдсэн орц, хэмжээнээс үл хамааран зөвхөн тухайн хоолонд хэдэн төгрөг зарцуулсан нийт үнийн дүнг бичиж тэмдэглэнэ.

Багана 13. Өдрийн тэмдэглэл хөтөлж буй өдөр өглөөний цай, өдрийн хоол, оройн хоол, зууш, ус, ундаа, кофе, цай, архи согтууруулах ундаа, гэртээ авчирч хооллосон бэлэн хоол, хүнс тус бүрийн хувьд бусдаар худалдан авахуулж идсэн нийт үнийг бичнэ. Жишээ нь, өрхийн 3 гишүүний нэг нь өдрийн хоолоо 10000 төгрөгөөр худалдан авч идсэн, харин нөгөө 2 нь найзуудаараа 7000, 5000 төгрөгийн хоол худалдан авахуулж идсэн бол Багана 12-т 10000 төгрөг, Багана 13-т 12000 төгрөг гэж нөхөгдөнө.

Мэдээлэл цуглуулагч:

Өдрийн тэмдэглэлийг өрхөд үлдээхдээ өдрийн тэмдэглэлийн ард байрлах өрхийн гадуур хооллолтын хэрэглээ өдөр өдрөөр бүртгэх ёстойг заавал тайлбарлаж үлдээх.

Өдрийн тэмдэглэлийн хөтлөлтийг сайтар шалгах ба гадуур хооллосон хэрэглээний хөтлөлтийг шалгаж, хэрэв нөхөгдөөгүй бол өрхийн гишүүдээс тодруулж, бүртгэнэ үү.

ХЭСЭГ Б. ГЭРЭЭСЭЭ ГАДУУР ХЭРЭГЛЭСЭН ӨРХИЙН ХҮНСНИЙ ХЭРЭГЛЭЭ

Хэсэг А-д бичигдсэн хүнсний бүтээгдэхүүнтэй давхцах ёсгүй

МӨРИЙН ДУГААР	9 Гэрээсээ гадуур хэрэглэсэн зүйлсийн нэр төрөл	10		11	12	13
		Танай өрхийн гишүүд дараах [НЭР ТӨРӨЛ]-д гэрээсээ гадуур хооллож, зардал гаргасан уу/бусдаас үнэгүй авсан уу?		Танай өрхийн гишүүд нийт хэдэн удаа [НЭР ТӨРӨЛ]-д зардал гаргасан/бусдаас үнэгүй авсан бэ?	Танай өрхийн гишүүд [НЭР ТӨРӨЛ]-д нийт хэчнээн төгрөг зарцуулсан бэ?	Танай өрхийн гишүүд нийт хэчнээн төгрөгийн [НЭР ТӨРӨЛ]-ийг бусдаас үнэгүй авсан/ хооллосон бэ?
		Тийм 1 Үгүй 2 → ДНТ*		Тоо	Төгрөг	Төгрөг
ЭХНИЙ ӨДӨР						
0001	Өглөөний цай	1	2			
0002	Өдрийн хоол	1	2			
0003	Оройн хоол	1	2			
0004	Зууш	1	2			
0005	Уух зүйлс (ус, ундаа, кофе, цай гэх мэт)	1	2			
0006	Уух зүйлс (архи, согтууруулах ундаа)	1	2			
0007	Бэлэн хоол, хүнс (гэрээсээ өөр газарт бэлтгэсэн хоол, хүнсийг худалдан авч гэртээ хооллосныг оруулна.)	1	2			
ХОЁР ДАХЬ ӨДӨР						
0001	Өглөөний цай	1	2			
0002	Өдрийн хоол	1	2			
0003	Оройн хоол	1	2			
0004	Зууш	1	2			
0005	Уух зүйлс (ус, ундаа, кофе, цай гэх мэт)	1	2			
0006	Уух зүйлс (архи, согтууруулах ундаа)	1	2			
0007	Бэлэн хоол, хүнс (гэрээсээ өөр газарт бэлтгэсэн хоол, хүнсийг худалдан авч гэртээ хооллосныг оруулна.)	1	2			
ГУРАВ ДАХЬ ӨДӨР						
0001	Өглөөний цай	1	2			
0002	Өдрийн хоол	1	2			
0003	Оройн хоол	1	2			
0004	Зууш	1	2			
0005	Уух зүйлс (ус, ундаа, кофе, цай гэх мэт)	1	2			
0006	Уух зүйлс (архи, согтууруулах ундаа)	1	2			
0007	Бэлэн хоол, хүнс (гэрээсээ өөр газарт бэлтгэсэн хоол, хүнсийг худалдан авч гэртээ хооллосныг оруулна.)	1	2			
ДӨРӨВ ДЭХ ӨДӨР						
0001	Өглөөний цай	1	2			
0002	Өдрийн хоол	1	2			
0003	Оройн хоол	1	2			
0004	Зууш	1	2			
0005	Уух зүйлс (ус, ундаа, кофе, цай гэх мэт)	1	2			
0006	Уух зүйлс (архи, согтууруулах ундаа)	1	2			
0007	Бэлэн хоол, хүнс (гэрээсээ өөр газарт бэлтгэсэн хоол, хүнсийг худалдан авч гэртээ хооллосныг оруулна.)	1	2			

ҮНЭЛЖ БИЧНЭ ҮҮ.

ХЭСЭГ Б. ГЭРЭЭСЭЭ ГАДУУР ХЭРЭГЛЭСЭН ӨРХИЙН ХҮНСНИЙ ХЭРЭГЛЭЭ

Хэсэг А-д бичигдсэн хүнсний бүтээгдэхүүнтэй давхцах ёсгүй

МӨРИЙН ДУГААР	9 Гэрээсээ гадуур хэрэглэсэн зүйлсийн нэр төрөл	10		11	12	13
		Танай өрхийн гишүүд дараах [НЭР ТӨРӨЛ]-д гэрээсээ гадуур хооллож, зардал гаргасан уу/бусдаас үнэгүй авсан уу?		Танай өрхийн гишүүд нийт хэдэн удаа [НЭР ТӨРӨЛ]-д зардал гаргасан/бусдаас үнэгүй авсан бэ?	Танай өрхийн гишүүд [НЭР ТӨРӨЛ]-д нийт хэчнээн төгрөг зарцуулсан бэ?	Танай өрхийн гишүүд нийт хэчнээн төгрөгийн [НЭР ТӨРӨЛ]-ийг бусдаас үнэгүй авсан/ хооллосон бэ?
		Тийм 1	Үгүй 2 → ДНТ*	Тоо	Төгрөг	Төгрөг
ТАВ ДАХЬ ӨДӨР						
0001	Өглөөний цай	1	2			
0002	Өдрийн хоол	1	2			
0003	Оройн хоол	1	2			
0004	Зууш	1	2			
0005	Уух зүйлс (ус, ундаа, кофе, цай гэх мэт)	1	2			
0006	Уух зүйлс (архи, согтууруулах ундаа)	1	2			
0007	Бэлэн хоол, хүнс (гэрээсээ өөр газарт бэлтгэсэн хоол, хүнсийг худалдан авч гэртээ хооллосныг оруулна.)	1	2			
ЗУРГАА ДАХЬ ӨДӨР						
0001	Өглөөний цай	1	2			
0002	Өдрийн хоол	1	2			
0003	Оройн хоол	1	2			
0004	Зууш	1	2			
0005	Уух зүйлс (ус, ундаа, кофе, цай гэх мэт)	1	2			
0006	Уух зүйлс (архи, согтууруулах ундаа)	1	2			
0007	Бэлэн хоол, хүнс (гэрээсээ өөр газарт бэлтгэсэн хоол, хүнсийг худалдан авч гэртээ хооллосныг оруулна.)	1	2			
ДОЛОО ДАХЬ ӨДӨР						
0001	Өглөөний цай	1	2			
0002	Өдрийн хоол	1	2			
0003	Оройн хоол	1	2			
0004	Зууш	1	2			
0005	Уух зүйлс (ус, ундаа, кофе, цай гэх мэт)	1	2			
0006	Уух зүйлс (архи, согтууруулах ундаа)	1	2			
0007	Бэлэн хоол, хүнс (гэрээсээ өөр газарт бэлтгэсэн хоол, хүнсийг худалдан авч гэртээ хооллосныг оруулна.)	1	2			

* - Дараагийн нэр төрөл